

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Эх орондоо хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг хангах, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэх, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон Монголын ард түмэн ардчилсан Үндсэн хуулиа баталж, даяар олноо тунхаглан зарласан билээ.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд иргэн хүн хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх эрхийг баталгаатай эдлэх, шүүхийн өмнө иргэн бүр эрх тэгш байхаар заасан.

Монгол Улсын нэгдэн орсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. ...", мөн 26 дугаар зүйлд "Бүх хүн хуулийн өмнө тэгш байх бөгөөд аливаа алагчлалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрхтэй. ..." гэж мөн заасан.

Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцсан үүргийн хүрээнд хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, гэм буруу нь шүүхээр тогтоогдоогүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд үл тооцох, гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох, шударгаар ял оногдуулах, цагаатгах, хэлмэгдүүлэлт гаргахгүй байх, гэх мэт зорилтыг хэрэгжүүлэх гол харилцааг Үндсэн хууль батлагдсан өдрөөс хойш 1992-2017 хүртэл хугацаанд Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар, 2017 оноос Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулж байна. Хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол хөндөгддөг нийгмийн харилцаа бол эрүүгийн процессын эрх зүйн харилцаа юм.

Монгол Улсад эрүүгийн процессын эрх зүйн харилцаа "байцаан шийтгэх" зарчимтайгаар 1963 оны 12 дугаар сарын 24 ба 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар зохицуулагдаж байсан. Харин 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр "байцаан шийтгэх" харилцаа нь "хянан шийдвэрлэх"

болон өөрчлөгдөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нэртэйгээр батлагдан одоо хүчин төгөлдөр үйлчилж байна.

“Байцаан шийтгэх” ба “хянан шийдвэрлэх” харилцаа нь нэршлээс гадна тогтоож байгаа зарчим нь эрс ялгаатай. Байцаан шийтгэх зарчим нь нэг талын буюу эрх мэдэл бүхий төр түүний байгууллага, албан тушаалтны эрх мэдэл процессын эрх зүйн харилцаанд оролцогчдоос илүү хүчин чадалтай байж үйлдэгдсэн гэмт хэргийн шалган шийдвэрлэхэд оршдог. Хянан шийдвэрлэх ажиллагаа нь мэдүүлэг /байцаалт/-ээс гадна тэгш мэтгэлцээний үндэс болсон нотлох баримтад тулгуурлан талуудын оролцоог тэгш ханган хэргийг хянан шийдвэрлэхэд оршдог.

Энэ ч агуулгаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлд нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгах, хянах үүргийг мөрдөгч, прокурорт үлдээн, харин шүүх нь хэргийн бодит байдлыг талуудын мэтгэлцээний үндсэн дээр тогтоох байдлаар өөрчлөгдөн батлагдсан.

Тодруулбал Эрүүгийн байцаан шийтгэх хууль /1963/-ийн 21-р зүйлд “**Шүүх...** нь хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шинжлэхийн тулд хуульд заасан бүх арга хэмжээг авч яллагдагчийг яллах ба цагаатгах, хэргийг нь хүндрүүлэх ба хөнгөрүүлэх байдлыг илрүүлэх **үүрэгтэй.**”, Эрүүгийн байцаан шийтгэх хууль /2002/-ийн 16.1-д “...**шүүх** нь хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор нотлохын тулд хуульд заасан бүх арга хэмжээг авч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг яллах ба цагаатгах, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх ба хөнгөрүүлэх нөхцөл байдлыг бүрэн тогтоох **үүрэгтэй.**” гэж заасан байсан.

Өөрөөр хэлбэл шүүх хэргийн бодит байдлыг тогтоох нь зарчим эрс өөрчлөгдсөн. Хэдий тийм ч энэхүү зарчим хуульд хэрхэн хэрэгжих талаар процессын ажиллагааг нарийвчлан зохицуулсан зохицуулалт дутуу болон хийгээгүй орхигдуулсан. Тиймээс шүүх хэргийг бодит байдлыг аль нэг талд давуу байдал олгохгүйгээр талуудын мэтгэлцээнд үндэслэн тогтоох талаарх процессын зохицуулалтын боловсронгуй болгох хууль зүйн шаардлагатай байна. Энэ нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т заасан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдлыг хангах нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим, шударга шүүхээр шүүлгэх, иргэн бүр шүүхийн өмнө тэгш эрхтэй байх зарчим бүрэн дүүрэн хэрэгжихэд томоохон алхам болох юм.

Тиймээс эрүүгийн хэрэг шийдвэрлэх процессын эрх зүй “байцаан шийтгэх” зарчмаас “хянан шийдвэрлэх” зарчимд шилжсэнийг харгалзан, уг зарчимд тулгуурлан тухайн харилцааг зохицуулж байгаа холбогдох хуулийн бусад зарчим, хэм хэмжээг нийцүүлэх хууль зүйн шаардлага зүй ёсоор тулгарч байна. Нөгөөтэйгөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах эрх бүхий этгээдийн хараат бус бие даасан байдлыг хангахын тулд эрх зүйн орчныг сайжруулах замаар процессын эрх зүйн харилцаанд оролцогч ба мөрдөх, яллах талын харилцааг тэгш байдлыг хангах, шүүх этгээдийн хараат бус байдлыг бататгах шаардлагатай.

Авлига нь нийгмийн тогтвортой болон аюулгүй байдалд үүсгэж буй бэрхшээл, аюул занал нь ардчилсан тогтолцоо, үнэт зүйлс, шударга ёсыг сулруулж, тогтвортой хөгжил, хууль дээдлэх, шүүх хараат бус байх, шүүхийн өмнө эрх тэгш байх ёсонд ноцтой хохирол учруулдаг. Энэхүү асуудал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ч үүсдэг. Манай улс авлигын индексээр 2016 онд 180 орчим орноос 87-д байсан бол 2024 онд 121 болон 34 нэгжээр ухарсан. Тиймээс хэрэг хянан шийдвэрлэх шатанд авлигаас урьдчилан сэргийлэх, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын үзэл санаанд авлигын эсрэг хууль тогтоомжийг нийцүүлэх, зөв томъёолох, авлигын эсрэг тэмцлийн хэрэгцээ шаардлагыг буруугаар ашиглахгүй байх, шударгаар шүүлгэх иргэний үндсэн эрхийг хангах, шүүхийн өмнө аль нэг талд давуу байдал олгох хууль эрх зүйн орчин нь шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмыг алдагдуулж байгааг засан сайжруулах шаардлагатай. Монгол Улсын Үндсэн хуулийн Монгол Улсын төрийн байгуулалт 3-р бүлгийн “Шүүх эрх мэдэл” дэд бүлэгт прокурорыг хамааруулан заасан байдаг. Энэ нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Үндсэн хууль дахь төрийн эрх мэдлийн хуваарилалтаар прокурор нь шүүх эрх мэдэлд хамаардгийг илэрхийлэг. Нэгэнт шүүх эрх мэдэлд хамаарч байгаа тохиолдолд прокурорын үйл ажиллагааны үндсэн зарчим нь хараат бус байж гагцхүү хуульд захирагдахад оршино. Энэ дагуу Прокурорын тухай хуулийн 3.1.4 дэх заалт, 7-р зүйлд тус тус прокурорын хараат бус байдлыг баталгаажуулсан. Харин Прокурорын тухай хуулийн 6.1-д прокурор нь дээд шатны прокурорын өмнө ажлаа хариуцах талаар заасан нь прокурорын хараат бус, бие даасан зарчимтай зөрчилддөг. Прокурор нь шударга ёс, хууль дээдлэх ёсыг тогтоож хамгаалах үндсэн чиг үүрэгтэйгээр төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцдог этгээд байтал дээд шатны албан тушаалтнаас хараат байж, түүнд ажлаа тайлагнаж хариуцах болж байгаа прокурорын хараат бус байдалд нийцэхгүй. Улмаар прокурор нь дээд шатны албан тушаалтнаас буюу захирах, захирагдах ёсны хүрээнд үйл ажиллагаа явуулах нь иргэний шударгаар шүүлгэх эрхийг дордуулах нөхцөл байдал бий болгож болзошгүй юм. Нөгөө талаар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар прокурор нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зохих зөвшөөрлийг авсан хуульч байдаг. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6.4-т хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа хараат бус байх талаар тусгайлан заасан байдаг. Тиймээс прокурор нь хуульчийн хувьд дээд шатны албан тушаалтнаас хараат, ажлаа буюу бусдыг яллах, эрүүгийн хэрэгт хяналт тавих ажлаа гэх мэт үндсэн ажлаа дээд шатны этгээдэд тайлагнаж хариуцдаг байх нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зарчимд нийцэхгүй. Тиймээс прокурорын хараат бус байдлыг хангах замаар иргэний шударгаар шүүлгэх эрхийг хангах нь нь Үндсэн хууль, бусад хуульд заасан зарчмыг хэрэгжүүлэх шаардлага болж байна.

1.2.Практик шаардлага

Улсын яллагч буюу прокурор нь шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс, оролцогчид нь өөрийн нэрийн өмнөөс, тэдгээрийн өмгөөлөгч нь үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан тус тус оролцдог. Манай улсын үндэсний эрх зүйн тогтолцооноос хамаарч шүүх байгууллага нь төрийн байгууллагад, шүүгч нь төрийн жинхэнэ албан хаагч ангилалд хамаардаг хэдий ч шүүх нь төрөөс илүү өргөн

агуулгатай буюу Монгол Улсын нэрийн өмнөөс хэрэг маргааныг шийдвэрлэж, шийдвэр гаргадаг ба энэ нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим юм.

Тийм учраас шүүх нь аль ч тохиолдолд маргалдагч, мэтгэлцэгч талуудын аль нэг талд нь ялангуяа төрийн талд орохгүй, аль нэг талыг дэмжихгүй байх нь шударга шүүхийн үндсэн шинж чанар юм. Харин талуудын эрх тэгш мэтгэлцээний үндсэн дээр бодит байдлыг тогтоох нь нэг талаас шударга шүүхийн зарчим нөгөө талаас иргэний шударга шүүхээр шүүлгэх үндсэн эрхэд нийцэх юм. Тиймээс шүүх нь яллагч тал /төр түүнийг төлөөлсөн прокурор, мөрдөгч/-д ямар ч давуу байдал олгохгүй байх, талуудын тэнцвэрт байдлыг хадгалах, энэ зарчмыг бэхжүүлэн хуульчлан тогтоох нь хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчимд практикт бодит биеллээ олоход бодит алхам болно гэж үзэж байна.

Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 07 дүгнэлтэд "...Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад тусгасан "шударга шүүхээр шүүлгэх эрх"-ийн хүрээ нь олон улсын эрх зүйд хүлээн зөвшөөрөгдсөн "шударгаар шүүлгэх эрх"-ийн агуулгатай дүйцэж байгаа бөгөөд шүүхийн өмнөх, түүнчлэн шүүх хуралдааны болон түүний дараах үе шатанд эдлэх цогц эрхийг илэрхийлсэн өргөн агуулгатай ойлголт болно. Тухайлбал, хуулийн дагуу байгуулагдсан, бүрэн эрх бүхий, алагчлалгүй шүүхээр хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх эрх төдий бус, шүүх хуралдаанаас өмнө эрх зүйн туслалцаа авах, өмгөөлөгчөө сонгох, ялласан, баривчилсан үндэслэлийг мэдэх, эрүү шүүлтэд өртөхгүй байх, хүнлэг нөхцөлд хоригдох, хэргийг цаг алдалгүй шийдвэрлүүлэх, нотлох баримт шалгуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд талууд эрх тэгш байж, тэгш боломжоор хангагдах, ялгаварлан гадуурхлаас ангид байх зэрэг нь дээрх эрхийн хүрээнд багтаж байна..." гэсэн байдаг.

Тиймээс шударгаар шүүлгэх иргэний үндсэн эрхийн хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд талуудын тэгш байдлыг хангах, өмгөөлөх талын идэвх, оролцоог яллах талтай тэнцвэржүүлэх, өөрийгөө өмгөөлөх эрхийг хангах, шүүх нь хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ төвийг сахисан байр суурийг боловсронгуй болгох, хэргийг түргэн шуурхай бөгөөд яллах ба цагаатгах талуудын тэнцвэртэй мэтгэлцээнийг хангах, нотлох баримтад тулгуурлах, эсрэг тэсрэг нотлох баримт байгаа тохиолдолд шүүхээс гадна мөрдөгч, прокурор нь зайлшгүй үнэлдэг байх, шүүх хуралдаанд талуудын өгсөн мэдүүлэг, тайлбар, дүгнэлт нь шүүхийн шийдвэрт тусгагддаг байх, эдгээрт болон нотлох баримтад шүүхийн шийдвэр үндэслэдэг байх, тухайн хэрэг маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай тохиолдолд шүүхээс хуулийг тайлбарлан хэрэглэдэг байх, шударга шүүхийн нэг шинж болох хараат бус байдлыг бататгах, ялангуяа шүүгч шүүгчээс хараат, нөлөөлөх болзошгүйг хязгаарлах зэрэг эрх зүйн хэм хэмжээг боловсронгуй болгох шаардлага практикт байсаар байна.

Мөн Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 10 дүгнэлтэд "... гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа этгээдийн эрх зүйн байдлыг дээрх хуулиар нарийвчлан зохицуулж өгөөгүйн улмаас тухайн этгээдээс гэрчийн мэдүүлэг авч, түүний эрхийг хөндөх байдал гаргахаар байгааг хууль тогтоогч анхаарч, хуулийн зохицуулалтыг боловсронгуй

болгох шаардлага байна. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн иргэнд өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэргүүн ээлжид танилцуулж, мэдүүлэг өгөх тохиолдолд худал мэдүүлбэл хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг сануулах журмыг илүү тодорхой хуульчлах нь зүйтэй...” гэж дурдсан.

Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2020 оны 85 дугаар тогтоолын дагуу шинжээчээр томилогдсон доктор (Ph.D), профессор Т.Оюунчимэг нь “...Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад "Иргэн нь өөрийнхөө болон гэр бүлийн гишүүдийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, ..." буюу дуугүй байх эрхтэй гэж заасан. Хүн өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх нь тухайн хүний субъектив эрх учраас тухайн этгээдийн сонгох боломж гэж үзэж болно.” гэж дүгнэсэн байдаг.

Тиймээс гэрч болсон хүнд өөрийгөө мөн өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, ялангуяа мөрдөх этгээдийн зүй бус үйлдлээс хамгаалах, буруу зөрүү мэдүүлэг өгөхөөс урьдчилан сэргийлэх, гэрчийг гэрчийн мэдүүлэг өгөхийг албадахыг хориглох, гэрч нь хөтөлсөн, тулгасан асуултад хариулахгүй байх, хууль зөрчиж авсан мэдүүлгийг хууль бус баримтад тооцох, өөрийнхөө болон гэр бүлийн гишүүдийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг баталгаажуулах, эрхийг нь урьдчилан сануулах, мэдэгдэх, гэрчээс мэдүүлэг авахад өөрийнх нь өмгөөлөгчөөс гадна эрх ашиг нь хөндөгдөж байгаа этгээдийн өмгөөлөгчийг зайлшгүй оролцуулдаг болохтой холбоотой харилцааг боловсронгуй болгох нэн шаардлагатай байна. Түүнчлэн гэрч байсан этгээд хожим сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч болсон тохиолдолд түүний гэрчээр өгсөн мэдүүлгийг нотлох баримтаар үнэлдэггүй байх, нотлох баримтаас хасдаг байх, гэмт хэрэг үйлдсэн талаар бодит нотлох баримт байгаа, бусад гэрч заасан, гомдол, өргөдөлд нэр нь дурдагдсан этгээдийг гэрчээр асуудаггүй байх зэрэг асуудлыг нарийвчлан тусгах шаардлагатай байна. Үүнээс гадна гэмт хэрэгт сэрдэгдэж байгаа этгээдэд “өөрийнхөө болон гэр бүлийн гишүүдийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх буюу дуугүй байх эрх”-ийг баталгаажуулах зайлшгүй шаардлага байна. Иргэн хүн бүр эрх зүйн тодорхой мэдлэгтэй байх боломжгүй. Ямар мэдүүлэг нь өөрийнх болон гэр бүлийн гишүүнийх нь эсрэг мэдүүлэг байхыг тэр бүр мэдэх боломжгүй. Тиймээс гэмт хэрэгт сэрдэгдсэн аливаа этгээдэд дуугүй байх эрхтэй байх, энэ эрхийг нь урьдчилан заавал сануулах, улмаар мэдүүлэг өгөхийг албадсан, хуурсан, амласан, айлгасан тохиолдолд мэдүүлгийг хууль бус нотлох баримтад тооцдог байх шаардлагатай байна.

АНУ-ын Дээд шүүхийн энэ шийдвэрийн үр дүнд “Мирандагийн анхааруулга” (Miranda Warning) хэмээх ойлголт хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд тавигдах нэг стандарт болж төлөвшсөн юм. Аливаа этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэж сэрдэн мэдүүлэг авахад өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, дуугүй байх, өмгөөлөгч авах эрхийг нь заавал урьдчилан танилцуулахын зэрэгцээ байцаалтын явцад эдгээр эрхийг нь хангаж мэдүүлэг өгөхөөс татгалзсан тохиолдолд байцаалтыг нэн даруй зогсоодог болсон юм. Өдгөө энэ стандартыг эрх зүйт ёс, хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг төлөвшүүлэхээр зорьж буй бүх улсын Үндсэн хууль,

Эрүүгийн процессын хууль тогтоомжид тусгаж, хэлбэрэлтгүй баталгаажуулсан бөгөөд эрх зүйн зайлшгүй процессын (Due Process of Law) стандарт болон тогтсон байна.

Энэ талаар Дээд шүүхийн 2023-04-14-ний өдрийн №16 тогтоолд "...1.1.Гэмт хэрэгт сэжиглэх илт үндэслэл буй бол хүнийг гэрчээр байцааж болохгүй ба гэрчийг байцааж байх үед мэдүүлгээс тийм үндэслэл илэрсэн даруйд байцаалтыг зогсоох ба Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг танилцуулан зөвхөн зөвшөөрсөн тохиолдолд хувийн байдлыг тогтоох, мэдүүлэг авах ажиллагааг явуулна. 1.3.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс мэдүүлэг авах нь юуны өмнө түүнд өөрийгөө өмгөөлөх, хамгаалах боломж олгож буй тул эхэлж ямар хэрэгт сэрдэгдэж эсвэл яллагдаж буйг заавал мэдэгдэх ба учир битүүлэг байдлаар байцаах, мэдүүлэг өгөхийг шаардах явдал гаргаж болохгүй. Тэрээр хэргийн талаар мэдүүлэх, түүнчлэн гэм буруугүй болон хэргийн бусад байдлыг нотлох үүрэг хүлээхгүй болохыг мөн өөрийг нь холбогдуулан сэжиглэж яллаж буй хэргийг мэдэх эрхтэй болохыг мэдүүлэг авах явцад байнга анхаарна. 1.9.Хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж эсхүл өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнх нь эсрэг албадан авсан, түүнчлэн бусад хэлбэрээр мэдүүлэг гаргуулахаар шаардаж, шахалт үзүүлж, хүч хэрэглэн гэм бурууг хүлээхийг тулган шаардаж, хууран мэхэлж, хууль бус хөнгөлөлт амлаж, авсан мэдүүлгийг шүүгдэгчийн гэм бурууг нотлох баримтаас хасах ба энэ нь эрүүдэн шүүх гэмт хэргийг нотлох баримтад тооцоход саад учруулахгүй." гэсэн байдаг.

Манай улсын эрх зүйн тогтолцоо "хууль дээдлэх" зарчимд тулгуурладаг. Тиймээс Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, Улсын дээд шүүхийн шийдвэр, тайлбар шууд эрх зүйн эх сурвалж болдоггүй. Тиймээс эдгээр шийдвэрт тусгалаа олсон зарчим, дүгнэлт, тайлбарыг хуульчлан баталж байх нь хууль хэрэглээний практик ач холбогдолтой.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.1 дүгээр зүйлийн 13-т "Шүүх, прокурор, мөрдөгч тухайн хэрэгт хамааралтай энэ хуульд заасны дагуу цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг хэргийг хянан шийдвэрлэхэд хангалттай эсэхийг бүхэлд нь үнэлнэ." гэсэн зохицуулалтын улмаас практикт, хэрэгт хамааралтай байсан ч оролцогч тэдгээрийн өмгөөлөгчөөс нотлох баримт гаргуулах, нэмэлт мөрдөн байцаалт явуулах хүсэлтийг мөрдөгч, прокуророос гадна шүүгч гаргаж байна. Энэ нь урдаас хөдөлбөргүй үнэн гэсэн нотлох баримт байж болохгүй байх зарчмыг алдагдуулж оролцогчийн өөрийгөө өмгөөлөх эрхийг дордуулж, өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэх мэргэжлийн чиг үүрэгт саад болж, талууд хууль, шүүхийн өмнө эрх тэгш мэтгэлцэх боломжийг хязгаарлаж байгаа болно. Тиймээс эдгээр эрх, зарчимд нийцүүлэн холбогдох хуулийг өөрчлөх практик шаардлага зайлшгүй байна.

Үндсэн хуулийн Дөрөвдүгээр бүлэгт прокурор буюу яллах талыг төрийн шүүх эрх мэдэлд хамааруулсан. Шүүх эрх мэдлийн хүрээний эрх мэдэл нь хараат бус, бие даасан байх зарчимд тулгуурладаг. Шүүх эрх мэдлийн хүрээнд ажиллах эрхтэй этгээд нь хуульч байх талаар хуульд заасан. Тодруулбал Хуульчийн эрхзүйн

байдлын тухай хуулийн 19.6-д “Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн үндсэн дээр хуульч нь өмгөөлөгч, холбогдох хуульд заасан мэргэжлийн шалгалтад оролцож тэнцсэн тохиолдолд ...прокурор...-оор ажиллана.” гэсэн. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа хараат бус байх ба энэ нь шүүгчээс гадна хуульч этгээдийн хувьд прокурор ба өмгөөлөгч аль алинд нь хамаарна. Гэсэн хэдий ч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих эрхтэй хуульч этгээд болох прокурорт эрх мэдлийн босоо тогтолцоо буюу захирах захирагдах ёсны хэв шинж чанар хадгалагдсаар байгааг Үндсэн хуульд нийцүүлэх шаардлагатай байгаа болно. Өөрөөр хэлбэл хэргийн аль нэг оролцогч гомдол санал гаргаагүй байхад дээд шатны гэх эрх мэдлийн хуульч /прокурор/ нь доод шатны гэгдэх хуульчид /прокурорт/ заавар, зааварчилгаа үүрэг даалгавар өгөх, нөгөө талаас доод шатны прокурор нь дээд шатны прокурорт ажлаа хариуцах нь хуульчийн үйл ажиллагааны зарчимд нийцэхгүй байгаа билээ. Үүнийг залруулж хуульч прокурорын хараат бус байдлыг баталгаажуулах нь хэлмэгдэл үүсгэхгүй байхад онцгой ач холбогдолтой гэж үзэж байна. Иймд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өмгөөлөгч ба прокурорын тэгш байдлыг хангах, прокурорын хараат бус байдлыг баталгаажуулах, хэлмэгдүүлэлт үүсгэхгүй байх, үүнээс урьдчилан сэргийлэх, иргэний шударгаар шүүлгэх эрхийн баталгааг сайжруулах, шүүх санаачилгаараа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулдаггүй байх, гагцхүү шүүхийн өмнөх талуудын мэтгэлцээн, идэвхтэй ажиллагааны үндсэн дээр шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байх гэх мэт зарчмыг Үндсэн хууль, олон улсын гэрээ эрх зүйн баримт бичигт тусгагдсан зарчим, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчимд тулгуурлан баталгаажуулах шаардлагатай.

Үндсэн хуулийн цэцийн 2007-10-24-ны өдрийн 10 дүгнэлтэд “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэргийг нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр буюу шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт буцаах нь хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох зарчмын хүрээнд шүүхээс явуулж байгаа ажиллагаа гэж үзэх үндэслэлтэй байна.” гэсэн. Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсэг 2022-06-03-ны өдрийн хуулиар “Шүүхийн шатнаас урьдчилсан хэлэлцүүлэг рүү хэрэг буцаахгүй.” гэж өөрчлөгдсөн. Шүүхийн хэлэлцүүлэг, нотлох баримт шинжлэн судлах явцад үйл баримт, нотлох баримтыг тал бүрээс нь илүү дэлгэрэнгүй шинжлэн судалдаг. Энэ явцад гэрчийн мэдүүлэг өөрчлөгдөх, оролцогчийн мэдүүлэг өөрчлөгдөх, урьд илрээгүй шинэ нөхцөл байдал илэрч болно. Энэ тохиолдолд хуульд урьдчилсан хэлэлцүүлэг рүү буцаахгүй гэж нэгэнт хуульд заасан учир хэргийн нотлогдсон байдал, нотлох баримтууд эргэлзээтэй байсан хэдий ч шүүх хуралдааныг зайлшгүй үргэлжлүүлэх болсон. Хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох зарчмын хүрээнд шүүхийн хэлэлцүүлэг дууссаны дараа нэмэлт нотлох баримт шаардлагатай тохиолдолд талуудын хүсэлтээр шүүх хуралдааныг завсарлуулах, хойшлуулах асуудлыг шүүх шийдвэрлэж хэрэгт хамааралтай шинэ нотлох баримтыг шинжлэн судлах замаар хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох зарчмыг бүрэн дүүрэн хангах практик шаардлагатай байна.

Шүүхийн шинэтгэл олон нийтийн санаа бодол судалгааг Шүүхийн ерөнхий зөвлөл 2020 онд гаргасан. Уг судалгаанд “...Шүүгчийн шударга байдлын талаарх

санал бодол иргэд, ААНБ-ын хувьд нэлээд хуваагдмал байна. Мөн шүүгч хэрэг маргааныг 100 хувь шударгаар шийддэг гэх шүүгчдийн хувь хэмжээ 30 хувьтай байна. Мөн бусад салбарын 783 албан хаагчийн 11 хувь нь Шүүгч асуудал хэрэг маргааны 100 хувь, 21 хувь нь 80 хувийг шударгаар буюу хууль ёсны дагуу шийддэг гэж үзжээ. Шударга байдлыг нэгтгээд дүгнэвэл шүүгчид өөрсдийн шударга байдалд ихэнх нь буюу 80 хүртэлх хувь нь шударга гэж 95 хувь нь үзэж байгаа бол иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хувьд арай өөр бодолтой байна. Тэд шүүгч нарын дийлэнх нь буюу 80 хүртэлх хувь нь шударга гэж 1/3 нь үзэж байна. Лавшруулбал иргэд, ААНБ-ууд 2 шүүгч тутмын 1 нь шударга гэдэгт эргэлзээтэй байна. Энэ байдал бусад хуульчдын үнэлгээнд мөн адил дурдагджээ. Тухайлбал, прокурор, өмгөөлөгч, шийдвэр гүйцэтгэгчид шүүгчдийн шударга байдалд мөн адил хандсан байна.” Дээрх судалгааны үр дүн нь шүүхийн шударга байдлыг бэхжүүлэх зайлшгүй шаардлага байсаар байгааг илтгэж байна. Шүүхийн шударга байдлыг бэхжүүлэх нь олон зүйлийн хүчин зүйл байдгийн нэг нь процессын эрх зүйн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох явдал юм.

Үндсэн хуулийн цэцийн 2017-04-12-ны өдрийн 03 дүгнэлтэд “Хяналтын шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зөвхөн анхан болон давж заалдах шатны шүүх эрүүгийн хэргийг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн эсэх, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн эсэх тухай хууль хэрэглээний асуудлыг хянан хэлэлцдэг онцлогтой”. гэсэн . Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн эсэх асуудлаар оролцогчид хяналтын шатны шүүхэд гомдол гаргах боломжгүй байгаа. Тиймээс энэ асуудлыг хуульчлах шаардлага байна.

Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 07 дүгнэлтэд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу хэргийг прокурорт буцаасан шүүхийн шийдвэр нь тухайн хэргийг бүхэлд нь хянан хэлэлцэж гаргасан шийдвэр бус, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд гаргаж буй явцын буюу завсрын шинжтэй шийдвэр тул тус зохицуулалт нь Үндсэн хуулиар баталгаажсан шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг хязгаарласан гэж үзэх үндэслэлгүй байна. Тодруулбал, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрх нь тухайн эрх зүйн маргааныг хянан хэлэлцээд эцэслэн шийдвэрлэж гаргасан шүүхийн шийдвэрт хамаарах ойлголт бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын (талуудын) хууль ёсны ашиг сонирхлыг хангахад чиглэгдсэн завсрын шинжтэй шийдвэрт гомдол гаргах нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасан шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхийг шууд хөндөхгүй болно. Энэ талаар Үндсэн хуулийн цэц 2007 онд 09 дүгээр дүгнэлт, 2020 онд 07 дугаар дүгнэлт тус тус гаргасныг тэмдэглэх нь зүйтэй.” гэсэн байдаг.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хэм хэмжээгээр мөрдөн байцаалтад буцаасан шийдвэрт хохирогч түүний өмгөөлөгч болон прокурор давж заалдах эсэргүүцэл, гомдол гаргах эрхтэй байгаа. Энэ нь тэдгээрийн эрх хэдий ч хэргийн бодит байдлыг тогтоох, шүүгдэгч түүний өмгөөлөгч нарын шаардсан, хүссэн цагаатгах нотлох баримт хэрэгт хамаарахгүй үлдэх, хэргийн бодит байдлыг тогтооход мэтгэлцэгч нэг талд давуу, нөгөө талд дутуу байдлыг үүсгэдэг.

Тиймээс Цэцийн шийдвэрт туссан “шүүхийн завсрын шинжтэй шийдвэр”-т буюу мөрдөн байцаалтад буцаасан шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй байх, оролцогч, түүний гаргасан хүсэлтийг хангаж анхан шатны шүүхээ шаардлагатай гэж үзсэн нотлох баримт, нэмэлт ажиллагааг хийж хэрэг маргааныг агуулгын хувьд эцэслэн шийдвэрлэх нь шударгаар шүүлгэх иргэний үндсэн эрх хангагдахад эерэг нөлөөтэй гэж үзэж байна.

Энэ талаар Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2020 оны 106 дугаар тогтоолын дагуу шинжээчээр томилогдсон Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн ухааны доктор Д.Баярсайхан дүгнэлтдээ “Эрүүгийн хэргийн талаарх анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг эрүүгийн процесст оролцогч талууд давж заалдах эрхтэй гэдгийг гадаадын ихэнх орны Үндсэн хуулиар бататган тогтоосон боловч, тэдгээрийн тайлбар болон шүүхийн практикт "хуульд үндэслэгдэх, хууль ёсны байх, тухайн шүүхийн шийдвэр хуулийг буруу хэрэглэсэн, гэмт хэргийн нөхцөл байдлыг буруу үнэлсэн байх гэсэн нотолгооны бодит үндэслэл бий болсон үед хэрэглэх тухай дурдсан нь олонтой. Өөрөөр хэлбэл, давж заалдах эрх нь "абсолют субъектив эрх" биш бөгөөд хуулиар тусгайлан өгөгдсөн хязгаарлагдмал эрх гэдгийг тэмдэглэсэн нь цөөнгүй.” гэсэн байдаг.

Доктор Д.Баярсайхан мөн дүгнэхдээ "Эрүүгийн процессын эрх зүйн шинжлэх ухаанд эрүүгийн хэргийг хяналтын журмаар хүлээн авч шийдвэрлэх Улсын дээд шүүхийн бүрэн эрхийг: а)Процедурын болон завсрын шийдвэр гаргах, б)Хэргийг эцэслэх буюу сүүлчийн шийдвэр гаргах гэж хоёр ангилалд ялган авч үздэг. Завсрын процесс гэдэг нь хяналтын журмаар гомдол эсэргүүцлийг Улсын дээд шүүхэд гаргасныг хуульд заасан харьяаллын болон түүний шаардлагыг хангасан эсэхийг урьдчилан хянаж хэсэгчлэн томилсон бүрэлдэхүүн бүхий шүүгч нарын (3 шүүгч) хэлэлцүүлгээр оруулж, Улсын дээд шүүхийн чиглэлийн шүүгч нарын хуралдаанд оруулах эсэхийг шийдвэрлэнэ. Энэ нь хэргийг шийдэх процесс биш, зөвхөн тухайн гомдол, эсэргүүцлийг хуульд заасан харьяаллын дагуу гаргасан эсэхийг хянан тогтооход чиглэгдсэн үйл явц юм. Харин хэргийг эцэслэн шийдэх Улсын дээд шүүхийн хуралдаан болон түүнээс гарах шийдвэр нь Улсын дээд шүүхийн эцсийн шийдвэр болно.” гэсэн байдаг. Улсын дээд шүүхэд гаргасан гомдлыг хяналтын шатны шүүх хуралдаанаар авч хэлэлцэх эсэхийг шийдэхэд хуульд заасан харьяаллын болон түүний шаардлагыг хангасан эсэхийг урьдчилан хянах хэм хэмжээг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Манай улсад хэрэг маргааныг шүүх хянан шийдвэрлэхдээ хэргийн харьяаллын дагуу “эрүү, иргэн, захиргаа”-ны хэрэг гэх байдлаар хэрэг маргаан үүсгэн хянан шийдвэрлэдэг. Хэргийн харьяаллын дагуу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль гэх хуулиуд тус тусын харилцааг зохицуулдаг. Хэргийн харьяаллаас хамаарч тухайн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх онцлог зааг ялгаа байдаг хэдий ч нийтлэг харилцаа мөн байдаг. Тухайлбал Үндсэн хуульд заасны дагуу шүүхийн өмнө иргэн бүр эрх тэгш байх зарчим. Түүнчлэн үүнд Үндсэн хуулиар баталгаажсан “Монгол Улсын хууль, олон

улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно.” гэх мэт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүний үндсэн эрхийн талаарх зохицуулалтууд хамаарна. Үүнээс гадна Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын шүүхийн тухай хуулиар зохицуулсан шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал, шүүх хууль дээдлэх, гагцхүү хуульд захирагдах, хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, мэтгэлцэх зарчим, гэм буруутайд тооцож үл болох, шүүхийн үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоо, шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх гэх мэт шүүхээс өөрийн үйл ажиллагаандаа ханган ажиллах зарчмууд мөн хамаарна. Тиймээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх зохион байгуулалтын нийтлэг харилцааны талаарх хэм хэмжээ аль нэг хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт орж байгаа тохиолдолд бусад хуульд тухайн өөрчлөлтийг агуулгын хувьд ижил төстэй байдлаар өөрчлөлт оруулж байх нь хууль хоорондын ойлгомжгүй байдал үүсэхгүй байх, хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байхад чухал ач холбогдолтой байдаг.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гаргасан 2015 оны мэдээнд иргэний хэргийн тухайд 24044 шүүх хуралдаан зарласнаас 11268 буюу 46,8 хувь нь хойшилж байсан бол 2022 оны мэдээнд дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн хэмжээнд хэргийг хэлэлцэх нийт 39,691 шүүх хуралдаан зарласнаас 21,619 буюу 54,4 хувь нь хойшилж байжээ. Шүүх хуралдаанд хойшлох үндсэн шалтгаан нь талуудын тэгш байдлыг хангах үндсэн зорилгыг агуулдаг хэдий ч олон дахин хойшлох нь шүүхэд итгэх итгэлийг сулруулах, талууд шүүх хуралдааны бэлтгэлд хайхрамжгүй хандах, эрх зөрчигдсөн түүнийгээ хамгаалуулахаар зорьж байгаа этгээдийн хувьд цаг хугацаа, сэтгэл зүйн, хөрөнгийн хохиролтой, шүүхэд зохиомол ачаалал үүсгэх гэх мэтчилэн сөрөг талууд байдаг. Тиймээс аливаа хэрэг маргаан зохих шатанд үүссэн үеэс оролцогч этгээдийг хариуцлагатай байлгах, эрхээ хамгаалах боломжийг олгох үүднээс эрхийг урьдчилсан танилцуулах, хэрэгт авагдсан баримт материалтай цаг алдалгүй танилцуулах, гаргасан хүсэлт гомдол нэг бүрийн үндэслэлийг хянан шийдвэрлэж хариу өгөх гэх мэт асуудлыг шийдвэрлэх замаар талуудын тэгш байдлыг хангаж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан хугацаанаас хэтрүүлэхгүйгээр хянан шийдвэрлэдэг байх талаар хууль тогтоомжийг боловсронгуй болгон зүй ёсны практик шаардлага байна.

Хоёр. Хуулийн төслөөр зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24.5-д “Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл нь дараах төрөлд хуваагдана: 24.5.1.хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай;" гэсний дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн төрлөөр боловсруулна.

Монгол Улсын иргэн шударга шүүхээр шүүлгэх буюу шударгаар шүүлгэх эрхийг бататгах, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах гэх мэт эрхийг бататгах, шүүхийн өмнө иргэн бүр эрх тэгш байх зармыг хангах, хэргийн бодит байдлыг талуудын мэтгэлцээний үндсэн дээр шүүх тогтоох зарчмыг хэрэгжүүлэх үүднээс энэ зарчимд нийцүүлэн дараах зүйлийг тусгана: Үүнд:

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэний Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрхийн хамгаалалт, хэрэгжилтийн асуудал;
- Өмгөөлөгч нь хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай ажиллагааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Өмгөөллийн тухай хуульд заасан эрхийн хүрээнд явуулах эрхийг хангах;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх харилцааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас бусад хуульд зохицуулсан бол мөн уг хуулийг хэрэглэх талаарх хуулийн заалтыг тодорхой болгох
- Эрүүгийн хуульд заасан орон байраас гадна бусад газар болох хүн, хуулийн этгээдийн орон байрнаас бусад өмчлөл, эзэмшлийн байр, байгууламж, бусад объектын халдашгүй байдлыг баталгаажуулах;
- Технологийн дэвшилтэй холбоотойгоор нийгмийн шинэ харилцаа үүсэж байгаатай холбогдуулан иргэний цахим харилцаа, төхөөрөмжийн нууцыг хамгаалах талаар;
- Яллах болон цагаатгах аль аль баримтыг шалгах явцад эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд ашигтайгаар шийдвэрлэх;
- Хэрэгт авагдсан баримт хангалттай үндэслэлээр хэргийн оролцогч, өмгөөлөгч нарын гаргасан нотлох баримт гаргуулах, мөрдөн байцаалт явуулах хүсэлтийг орхигдуулдаг байдлыг өөрчлөх;
- Хяналтын шатны шүүх хуралдаанаар Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн эсэх, зөрчсөн талаарх болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний Үндсэн хууль, олон улсын гэрээгээр баталгаажсан эрхийг хангаагүй, зөрчсөн талаарх гомдлыг хэлэлцэх талаар;
- Шүүх хуралдааныг цаг наргүй шөнөөс бусад явагддаг байдлыг өөрчилж, өдрийн буюу ажлын цагаар явуулдаг болох талаар;
- Төрийн нууцын ангиллаас шалтгаалж шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдаанд нууцын баталгаа гарган сонирхогч этгээд оролцдог болох талаар;
- Өмгөөллийн тухай хуульд заасан өмгөөлөгчийн эрхийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баталгаажуулах, Өмгөөллийн тухай хуульд заасан өмгөөлөгчийн эрхийг өргөтгөх;
- Яллагдагч буюу шүүгдэгчийн эрхийг тодорхой болгох;

- Яллагдагчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан гэж үзэх үндэслэл болохгүй үндэслэлүүд;
- Урьд гэрчээр мэдүүлэг өгсөн этгээд хожим яллагдагч, шүүгдэгч болсон тохиолдолд түүний гэрчээр өгсөн мэдүүлгийг нотлох баримтад тооцохгүй байх, мэдүүлгээсээ шалтгаалж хариуцлага тооцуулах эрх зүйн зохицуулалтыг өөрчлөх;
- Шүүгч хэрэг шийдвэрлэхдээ ашиг сонирхлын зөрчилтэй бол тэр уг хэргийг шийдвэрлэхээс татгалзах үндэслэл болох асуудал;
- Анхан шатны шүүгч урьд шийдвэрлэсэн хэргээ дахин шийдвэрлэж болохгүй байх асуудал;
- Хэлэлцэж байгаа хэрэгт харилцан зөрүүтэй нотлох баримтууд байгаа тохиолдолд аль нэгийг нь авсан бол бусдыг нь яагаад нотлох баримтаар тооцохгүй байгаа талаар үндэслэл;
- сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруугийн талаар хөдөлбөргүй үнэн гэж урьдчилан тогтоосон ямар ч нотлох баримт байж болохгүй талаарх заалтыг хуулийн нотлох баримт хэсэгт шилжүүлэх;
- Аль нэг оролцогчоос өөрийн үндэслэлээ тайлбарлаж байгаа нотлох баримтыг үнэлэхгүй орхигдуулах, мартахыг хориглох;
- Үзлэгийн явц нь бусдын хуулиар хамгаалагдсан халдашгүй байдалд халдах бол прокурорын зөвшөөрөл зайлшгүй авах, зөвшөөрлийг урьдчилан танилцуулах;
- Хэрэг бүртгэж, мөрдөн байцаах эрх бүхий этгээд нь ажиллагааны явцад урьдчилж олж мэдсэн зүйлээ батлах зорилгоор мэдүүлэг авахыг хориглох
- эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг танилцуулахдаа нэг хувийг өгөх, хэрэг бүртгэлийн хэрэгтэй танилцах боломжоор хангах, өөрийгөө өмгөөлөх боломжийг олгох, өөр асуудлаар яллах дүгнэлт үйлдэхгүй байх асуудал;
- Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрийнхөө болон гэр бүлийн гишүүнийхээ эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзах буюу дуугүй байх эрхийг баталгаажуулах;
- Оролцогч этгээд хэрэг хянан шийдвэрлэхэд нотолгооны ач холбогдолтой нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргах, гаргасан хүсэлтээ шийдвэрлүүлэх эрхийг хангах;
- Гэм буруугийн шүүх хуралдаанаас өмнө оролцогч нотлох баримт гаргаж өгөх боломжийг олгох;
- Яллагдагчаар татах тогтоол, яллах дүгнэлтэд тавигдах шаардлагыг дээшлүүлж хуульчлах;
- Хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад анхан шатны шүүхээс буцаасан тохиолдолд гомдол, эсэргүүцэл гаргадаггүй байх;
- Шүүх хуралдаанд прокурор босож үг хэлэхийг шаарддаггүй. Үүнтэй адилтгаж шүүгдэгчээс бусад этгээд үг хэлэх бол босож үг хэлэх эсэхээ өөрөө шийддэг байх;
- Шүүхийн хэлэлцүүлэг дууссаны дараа хэргийн бодит байдлыг тогтооход нэмэлт нотлох баримт шаардлагатай бол шүүх хуралдааныг завсарлуулах, уг хугацаанд шаардлагатай нотлох баримтыг хэлэлцэх;
- Хэргийн бодит байдлыг шүүхээс талуудын мэтгэлцээнийг үндэслэн тогтоох зарчмыг хэрэгжүүлэх үүднээс шүү хурлын тэмдэглэл гарах хүртэл шүүх

хуралдааныг завсарлуулах, зөвлөлдөх тасалгаанд шүүхийн шийдвэрийг бүрэн гаргаж, уншиж сонсох, гардуулах;

- Шүүхийн шийдвэрт тусах гэмт хэргийн талаарх нөхцөл байдлыг дэлгэрэнгүй болгох;
- Хохирогч түүний өмгөөлөгчөөс гэмт хэргийн асуудлаар зөвхөн хохирлын талаар гомдолтой байх;
- Аль ч шатны шүүх нь тухайн шатны шүүх хуралдаанаар хэлэлцээгүй асуудлаар шийдвэрийн үндэслэл болгохгүй байх;
- Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож ахин хэлэлцүүлэхээр гаргасан давж заалдах шатны шүүхийн шийдвэрт хяналтын журмаар гомдол гаргадаггүй байх;
- Хуульч мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг прокурорын босоо буюу захирах захирагдах ёсыг өөрчилж, хараат бус байдлыг баталгаажуулах
- Хэрэг бүртгэх ба мөрдөн байцаах хугацааны асуудал;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зарчмын өөрчлөлт оруулж байгаатай холбогдуулан бусад хуульд мөн өөрчлөлт оруулах асуудал.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгмийн үр дагавар, тэдгээрийн шийдвэрлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар эдийн засгийн хувьд нэмэлт зардал гарахгүй харин нийгмийн үр дагаврын хувьд эерэг нөлөө гарна гэж үзэж байна. Иргэний шударга шүүхээр шүүлгэх, өөрийгөө өмгөөлөх, өөрийнхөө болон гэр бүлийн гишүүнийхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх, шүүхийн өмнө мэтгэлцэгч талууд тэгш эрхтэй оролцох, шүүхээс хэргийг шийдвэрлэхдээ гагцхүү талуудын мэтгэлцээний үндсэн дээр бодит байдлыг тогтоохтой холбоотой зарчмууд бүрэн боломж илүү хангагдана.

Прокурор нь улсын яллагчийн хувьд нэг талаас хуульч, нөгөө талаас шүүх эрх мэдэлд хамаардаг этгээдийн хувьд хараат бус бие даасан байдал нь бэхэжнэ.

Хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагаанд оролцогч, ялангуяа мэргэжлийн өмгөөлөгчийн оролцоо нэмэгдэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд талуудын тэгш байдлын зарчим хангагдах боломж илүү бүрдэнэ. Хэрэг маргааныг түргэн шуурхай шийдвэрлэхийн зэрэгцээ бодит үнэнийг тогтоох ажиллагаанд талууд тэгш оролцоо хангагдана. Цаашдаа “хонгилын шүүх”, “хууль хяналтын байгууллагын хонгил” гэх мэт олон нийтэд үүссэн байдаг ойлголт эргэлзээг гаргах, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд хуулийн төслийн ач холбогдол оршино.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэх, холбогдох хууль тогтоомжтой уялдсан байдал, хуулийн төслийг дагалдан гарах хууль тогтоомжийн төслийн талаар

Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн

ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгын үүднээс хуулийн төслийг Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөө, иргэн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмыг бататган сайжруулах, прокурор, шүүгчийн хараат бус байдал, авлигаас ангид байдлыг бататгах үүднээс хуулийн төслийг боловсруулна. Энэ хүрээнд Өмгөөллийн тухай хууль, Шүүх шинжилгээний тухай хууль, Прокурорын тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Монгол Улсын шүүхийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон эдгээртэй холбоотой шаардлагатай бусад хууль нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36.1-д “Доор дурдсан хууль тогтоомжийн төслийг дараах хууль санаачлагч санаачилна:... 36.1.2... эрүү, иргэн, захиргааны ерөнхий` болон зөрчлийн тухай анхдагч хууль, шинэчилсэн найруулга...-ийн төслийг зөвхөн Засгийн газар санаачлах.” гэж заасан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл нь анхдагч хууль, шинэчилсэн найруулгын төсөл биш учир Улсын Их Хурлын гишүүн хууль санаачлах бүрэн эрхийн хүрээнд санаачлах нь Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нийцнэ.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ